



ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Тэмцээний зорилго:

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн шүүхийн мэтгэлцээний тэмцээний зорилго нь их, дээд сургуулийн оюутан, залуучуудад олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг сурталчилж, Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөн болон хүмүүнлэгийн үйл ажиллагааны тухай мэдлэг, ойлголт олгоход оршино.

Ерөнхий зохион байгуулагч:

- Олон улсын улаан загалмай хороо
- Монголын улаан загалмай нийгэмлэг

Хамтран зохион байгуулагч:

- Монголын өмгөөлөгчдийн холбоо
- Монголын хуульчдын холбоо
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар

Хамрах хүрээ:

Шүүхийн мэтгэлцээний тэмцээнд эрх зүйн чиглэлээр суралцаж буй бакалаврын хөтөлбөрийн оюутнууд болон бусад мэргэжлийн бакалавр болон магистрын хөтөлбөрийн оюутнууд оролцоно. Нэг баг нь хоёр илтгэгч оюутнаас бүрдэх бөгөөд сайн дурын үндсэн дээр судлаач оюутан болон дасгалжуулагчтай байж болно.

Тэмцээний журам:

Тэмцээн нь Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн бусад эх сурвалжийн хүрээнд Англи хэл дээр болно.

Бүртгэл:

Тэмцээний бүртгэлийг 10 дугаар сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд ihl@redcross.mn хаягаар хүлээн авна. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн шүүхийн мэтгэлцээнийг 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулна.

Техникийн зөвлөгөөн:

Техникийн зөвлөгөөнийг 2025 оны 10 дугаар сарын 21-ны өдөр 18:30 цагт Монголын улаан загалмай нийгэмлэгт зохион байгуулна.

Шагнал:

- | | | |
|--------------|---|--|
| Тэргүүн байр | - | Цом, өргөмжлөл, Хонг Конг хотод зохион байгуулах Ази-Номхон далайн бүсийн Улаан загалмайн Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн шүүхийн мэтгэлцээний тэмцээнд оролцох эрх, 3 оролцогчийн байр, нислэгийн зардал |
| Бусад байр | - | Өргөмжлөл, бэлэг дурсгалын зүйл |

Бусад:

Тэмцээний дэлгэрэнгүй мэдээллийг Монголын улаан загалмай нийгэмлэгийн Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хариуцсан ажилтан О.Манлайбаатар (manlaibaatar.o@redcross.mn; +976 91670011)-тай холбогдож авна уу.